



ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД  
Х.БАТТУЛГА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013. 11. 15 № 3/142 УАГ-Н/АР/2013/03-Н/А

Зөрчлийг арилгуулах тухай

Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ, вакцинуулалт болон Монгол мал үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийж буй аудитаар дараах зөрчил илэрлээ.

Мал эмнэлэг үржлийн газраас 2011 онд Архангай аймагт бруцеллөз өвчтэй малыг устгах нөхөн олговорт олгосон санхүүжилтийн 32,6 сая төгрөгөөр Цахир сумын Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын бусийн оффисын тавилга, компьютер, техник хэрэгсэл худалдан авсан, цалин болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан, 23,0 сая төгрөгөөр ачааны фургон машин, 22,0 сая төгрөгөөр аймгийн ХХААЖДҮГ-ын мал эмнэлгийн албандаа УАЗ-469 автомашин, 100,0 сая төгрөгөөр "Хурдан удмын адууны үржлийн аж ахуй эрхлэх" төсөлд дэмжлэг үзүүлэх нэрээр 55 тооны адууг хувь хүнд худалдан авч өгсөн, 40,0 сая төгрөгөөр мал эмнэлгийн явуулын лабораторийн автомашины гараж барьсан зэрэг нийт 217,6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д "босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлтэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой дараах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ", мөн "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 17 дугаар зүйлийн 17-ийн 1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага өгч байна.

070423

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулж, албан шаардлагын биелэлтийг 2014 оны 3 дугаар сарын 25-ны дотор гарган Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Золжаргал, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн П.Ганхуяг, Мал эмнэлэг, үржлийн газрын дарга М.Галбадрах, Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах нягтлан бодогч Н.Бат-Оюун нарт хариуцуулав.



АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

 Б.БОЛОРМАА